



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
М.СОНОМПИЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.30 № 03/40 ЧАТ-САТ/2014/32 - СТИА-ТНЭЗ

Зөрчил арилгуулах тухай

Эрчим хүчний сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараахь зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

Эрчим хүчний зохицуулагчдын зөвлөлийн 2002 оны 79 дүгээр тогтоолоор “Тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм” батлагдсанаар “Нэг худалдан авагч”-тай загварыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-иар дамжуулан хэрэгжүүлж ирсэн байна.

“Нэг худалдан авагч” загвар нь аж ахуйн харилцааны дүрэмд үндэслэн Эрчим хүчний зохицуулах газраас баталсан гэрээний дагуу Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэгчдээс худалдан авсан эрчим хүчийг түгээгч байгууллагад борлуулах процессын мөнгөн урсгалыг зүй зохистой байлгах зорилготой байгуулагдсан бөгөөд энэхүү нэгдсэн сүлжээнд цахилгаан эрчим хүч үйлдвэрлэгч, түгээгч 21, дамжуулагч 1 байгууллага холбогдон эрчим хүчний арилжаанд оролцож байна.

Гэвч Цахилгаан эрчим хүчний харилцааны “Нэг худалдан авагч” загварыг хэрэгжүүлэх үйл явц нь тус компанийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэгт байдаггүй учир хэрэгжиж эхэлсэн үеэс худалдан авагч, худалдагч байгууллагын цахилгаан эрчим хүчний авлага, өглөг, борлуулалтын ашиг орлого, мөнгөн урсгалын тооцоо буюу нэг худалдан авагчийн 2013 оны тайланд тусгагдсан 278.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, 283.7 тэрбум төгрөгийн зардал, 5.2 тэрбум төгрөгийн алдагдал, 14.0 тэрбум төгрөгийн авлага, 20.8 тэрбум төгрөгийн өглөгийн ажил гүйлгээний тайлагнал нь тус компанийн болон салбарын хэмжээний санхүүгийн тайлан тэнцэлд нэгтгэгдээгүй энэ талаарх тодорхой шийдвэр алга байна.

Түүнчлэн Цахилгаан эрчим хүчний төлбөр тооцоонд ногдуулсан болон хугацаандаа төлөөгүй алданги, график хазайлтын торгүүл, диспетчерийн горимын төлбөрт нэхэмжилсэн/НӨАТ/-ыг Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгаагүй байна.

Нэг худалдан авагч нь харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулаагүй, нийт авлага өглөгийн зөрүүгээр тооцоход 6.8 тэрбум төгрөгийн өр төлбөрийг ямар эх үүсвэрээс төлж барагдуулах нь тодорхойгүй, цаашид ч өр эрчимтэй өсөн нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, “Клин энержи” ХХК нь ЦЭХ-ний төлбөр болон хугацаандаа төлөөгүйн алданги 1.7 сая

ам доллар нэхэмжилж байгаа нь ирээдүйд ихээхэн хэмжээний эх үүсвэргүй болзошгүй өр төлбөр үүсэхээр байгаад Эрчим хүчний яам анхаарал хандуулах шаардлагатай байна.

Энэ нь 2007 онд батлагдсан Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 11.1.1-д “салхины эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 квт цахилгаан эрчим хүчийг 0.08-0.095 ам доллар”-ын хооронд тооцно гэж заасны дагуу “Клин энерги” ХХК-иас 1 квт эрчим хүчийг 0.095 ам доллараар худалдан авдаг боловч Диспетчерийн үндэсний төвөөс хязгаарласан эрчим хүч, ЭХЗХ-ны үнийн зохицуулалтын дагуу бага үнээр дамжуулан худалдаж байгаа нь эх үүсвэргүй өр өсөхөд нөлөөлж байна.

Эрчим хүчний нэг худалдан авагч нь тэг үлдэгдэлтэй дансад төлбөрөө төвлөрүүлж, ЭХЗХ-ноос баталсан мөнгөн урсгалыг хуваарийн дагуу гэрээт арилжааны банкаар дамжуулан үйлдвэрлэгч нарт хуваарилж байгаа тооцоог тулгахаас өөр хөндлөнгийн хяналт алга байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргана.” 19.1.2-т “батлагдсан маягт, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланг гаргах, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бараа импортлосон болон экспортлосон этгээд, түүнчлэн үйлдвэрлэсэн буюу борлуулсан, ажил үйлчилгээ үзүүлсэн иргэн хуулийн этгээд НӨАТ төлөгч байна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ыг үндэслэн

ШААРДАХ НЬ:

“Нэг худалдан авагч” загварын 2013 оны тайланд тусгагдсан борлуулалтын орлого, зардал, алдагдал, авлага, өглөгийн ажил гүйлгээний тайлагнал нь салбарын хэмжээний санхүүгийн тайлан тэнцэлд нэгтгэгдээгүй нийт авлага өглөгийн зөрүүгээр тооцоход 6.8 тэрбум төгрөгийн өр төлбөрийг ямар эх үүсвэрээс төлж барагдуулах нь тодорхойгүй байгааг анхаарч холбогдох хууль, журмын дагуу арга хэмжээ авч хэрэгжилтийг 2014 оны 10 дугаар сарын 30-ны дотор ирүүлэхийг Эрчим хүчний сайд М.Сономпилд хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР



Д.ГАНБИЛЭГ